

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН
АУДИТЫН ТАЙЛАН

**ЗОХИОГЧ, ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ АЖИЛЛАЖ,
ХЯНАЛТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ЗААСАН ХУГАЦААНД НЬ
ГҮЙЦЭТГҮҮЛЖ ЧАДАХГҮЙ БАЙГААГААС ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛСААР БАЙНА.**

АУДИТЫН КОД: ХӨА-2026/05-21-ШТА-НА

Хөвсгөл аймаг
2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: З.Даваадорж

Утас: 91890258 Цахим хаяг: Davaadorjz@audit.gov.mn

Аудитор: Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: gurbazarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. <https://audit.mn/audit>

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

З.Даваадорж

Аудитор

Н.Гүрбазар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2026 оны 04 дүгээр сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

**БҮЛЭГ 1. АЙМАГ, СУМДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХУУЛЬ
ЖУРАМД ЗААСАН ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГАД
НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.**

1.1 Төсөл, арга хэмжээнүүдийг хөгжлийн бодлогод
нийцүүлээгүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг
тооцоогүй, хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлж төлөвлөөгүй
байна.

1.2 Хууль, журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй
төсөл, арга хэмжээнүүд баталсан байна.

**БҮЛЭГ 2: ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНҮҮД БАТАЛСНААС ШАЛТГААЛАН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗАРЛАХ ХУГАЦААГ
БАРИМТЛААГҮЙ БАЙНА.**

2.1 Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга
хэмжээнээс шалтгаалан худалдан авах ажиллагааны
төлөвлөгөөнд заасан тендер зарлах хугацааг баримталж
ажиллаагүй байна.

2.2. Сангийн яам тендер шалгаруулалтад гаргасан гомдлыг
хянасан шийдвэрийн дагуу Үнэлгээний хороод нь дахин үнэлгээ
хийж гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулсан байна.

**БҮЛЭГ 3: ЗОХИОГЧ, ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ
АЖИЛЛАЖ, ХЯНАЛТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ЗААСАН
ХУГАЦААНД НЬ ГҮЙЦЭТГҮҮЛЖ ЧАДАХГҮЙ БАЙГААГААС
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛСААР БАЙНА.**

3.1. Зарим төсөл, арга хэмжээг зураг, төсөв гэрээнд заасан
хугацаанд гүйцэтгүүлээгүй байна.

3.2. Захиалагчийн хяналт нь хяналтыг хангалтгүй
хэрэгжүүлж, хяналтын ажлын үр нөлөөг бууруулж байна.

3.3. Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 1,367.8
сая төгрөгийг хөрөнгийг бүртгээгүй, Өрхийн үйлдвэрлэлийг
дэмжих тоног төхөөрөмж /Шаардлагатай сумдад/ төсөл, арга
хэмжээний үр дүнг тодорхойлох боломжгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Тайлангийн хавсралтууд

Холбогдох байгууллагуудын санал

Товчилсон үгийн тайлбар

АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АЗД	Аймгийн Засаг дарга
ҮАГ	Үндэсний аудитын газар
ШТА	Шууд тайлагнах аудит
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХШҮХ	Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл, арга хэмжээ
БОНХОБТХ	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ТШББ	Тендер шалгаруулалтын баримт бичиг
ТШЗ	Тендер шалгаруулалтын зааварчилгаа



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/16

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Эрх шилжүүлэх тухай” А/175 дугаар тушаалаар баталсан “ Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргын Тамгын газрын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв, холбогдох сумдын Засаг дарга нарт хүргүүлсүгэй.

3. “Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Д.Пүрэвдорж), аймгийн Засаг дарга (Л.Төмөрбаатар), Засаг даргын Тамгын газрын дарга(Р.Машбат), Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга(Э.Аззаяа), Орон нутгийн өмийн газрын дарга(Ц.Бэхбаяр), Худалдан авах ажиллагааны газрын дарга(Б.Базардамбуу) Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын захирал (Б.Ганзориг), Мөрөн сумын Засаг дарга(Х.Тайванбаяр), Эрдэнэбулган сумын Засаг дарга(Б.Эрдэнэнаран)нарт даалгасугай.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор(З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.

6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2026 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн *A/16* тоот тушаалын хоёрдугаар хавсралт

“Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

д/д	Албан шаардлагын утга	Хариуцах байгууллага	Акт, албан шаардлагын дугаар
1	Зөрчил арилгах тухай	Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ	130/A2270438/ ХӨА-2026/05-21-ШТА-НА

--ooOoo--

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторов 2025 оны Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д Монгол улсын Ерөнхий аудиторов баталсан нэгдсэн төлөвлөгөө, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов баталсан дэд төлөвлөгөөний дагуу аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх,
- ❖ Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх,
- ❖ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Хөвсгөл аймгийн аймаг, сумдын ИТХ-аас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээнүүд болон төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймаг, сумдын Засаг дарга, ЗДТГ, аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар Санхүү, төрийн сангийн хэлтэс, гүйцэтгэгч аж ахуй нэгж болон хяналтын чиг үүрэг бүхийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв, Мөрөн, Эрдэнэбулган сумдын холбогдох төрийн байгууллага, ажлын хэсгийн үйл ажиллагааг хамруулсан бол бусад сумдыг судалгааны түвшинд хамруулсан.

Аудитын хязгаарлалт:

Төсвийн хүндрэл, хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт баталсан сумдад ажиллах боломжгүй байлаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.

Хөвсгөл аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд баталсан төсөл, арга хэмжээнүүдийн төлөвлөлтийн баримт материал, ажлын тайлан, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний

хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймаг, сумдын Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд үндэслэн аудитын дүгнэлт, шийдвэрийг боловсруулж ажиллалаа.

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор З.Даваадорж, аудитор Н.Гүрбазар нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:

Хөвсгөл аймгийн 2025 оны төсвийг аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн III/31 дүгээр тогтоолоор баталж, тогтоолын 2, 5 дугаар хавсралтаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 31,693.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 15,672.0 сая төгрөгөөр санхүүжих 30 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн 2025 оны төсөвт аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 74 дугаар тогтоолоор тодотгол хийж, тодотголоор 17,943.3 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг хасаж, 10,319.7 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг нэмж, 2 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 987.6 сая төгрөгөөр нэмж батлан нийт төсөвт өртгийг 1,314.0 сая төгрөгөөр 2025 онд санхүүжих дүнг 752.4 сая төгрөгөөр тус тус хасаж тодотгон 30,379.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2025 онд 14,919.6 сая төгрөгөөр санхүүжих 28 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тогтоосон байна.

Тайланд онд өмнөх оноос шилжих 3,563.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээнд 918.5 сая төгрөгийн, шинээр хэрэгжих 26,815.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээнд 14,001.1 төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 онд шинээр болон үргэлжлэн хэрэгжих 27,853.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа явуулж 37 гүйцэтгэгчтэй 26,307.9 сая төгрөгийн гэрээ байгуулан 820.8 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гаргасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 23 төсөл, арга хэмжээнд 8,801.7 сая төгрөгийн санхүүжилт олгож төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл 59 хувьтай 20 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан байна.

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:

Тайлант 2025 онд 5 сум орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт баталсан байна. Хөрөнгө оруулалт баталсан сумдыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №1/ сая төгрөгөөр/

д/д	Сумын нэрс	Баталсан төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн	Олгосон санхүүжилт
1	Алаг-Эрдэнэ сум	1	140.0	140.0	-
2	Их-Уул сум	3	58.0	58.0	56.6
3	Цагаан-Уул сум	12	51.3	51.3	37.5
4	Эрдэнэбулган сум	51	2,217.6	2,203.6	347.1
5	Мөрөн сум	27	2,599.2	2,099.2	1,735.8
	Нийт	94	5,066.1	4,552.1	2,177.0

Хүснэгтэд үзүүлсэн 94 төсөл, арга хэмжээнээс 45 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссан бол 9 төсөл, арга хэмжээ хэрэгжилт дутуу, 40 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Хэрэгжээгүй 40 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл, арга хэмжээ нь төсвийн тодотголоор хасагдсан байна. Нийт төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлд 2,175.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

БҮЛЭГ 1:

АЙМАГ, СУМДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСАН ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

1.1 Төсөл, арга хэмжээнүүдийг хөгжлийн бодлогод нийцүүлээгүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй, хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлж төлөвлөөгүй байна.

1.1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын хөгжлийн бодлогын нийцлийн тухайд:

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжих 26,815.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээнээс 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Аймгийн Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах төсөл, арга хэмжээ Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцээгүй бол 16,251.6 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ Хөвсгөл аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна. /хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцээгүй төсөл арга хэмжээний жагсаалтыг хавсралт №1-ээс харна уу/ Харин төсөл, арга хэмжээнүүд нь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт бүрэн туссан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай хуульд зааснаар жил бүрийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор, төсвийг 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор буюу 2 сарын зайтай баталж байхад бодлогын зорилтыг уялдуулаагүй байгаа нь төсвийн төслийг боловсруулахдаа хөгжлийн зорилтуудаа үндэслээгүй, хөгжлийн жилийн төлөвлөгөөг иж бүрэн батлаагүй болохыг харуулж байна.

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын хөгжлийн бодлогын нийцлийн тухайд:

Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд сумын төсвийн хөрөнгө оруулалтыг тооцоогүй, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд зааснаар сум нь жилийн хөгжлийн төлөвлөгөө, хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл баталдаггүй тул сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан төсөл, арга хэмжээнүүд нь аймгийг хөгжүүлэх 5 жилийн чиглэл, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн эсэхэд хяналт хэрэгжүүллээ. Сумдын баталсан төсөл, арга хэмжээнүүдээс 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Мөрөн сумын ЗДТГ-ын Брэндбүүк бүтээх(зөвлөх үйлчилгээ), 140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-т автомашин худалдан авах төсөл, арга хэмжээнүүд нь Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх жилийн үндсэн чиглэлд нийцээгүй байна. Харин сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн байна.

1.1.2 Нэн тэргүүний хэрэгцээ шаардлагатай цахим систем, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг эрэмбэлж төлөвлөөгүй байна.

Тайлант онд аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж худалдан авах 3,514.0 сая төгрөгийн 37 төсөл, арга хэмжээг баталсан байна. Энэ нь нийт төсөвт өртгийн 10 хувийг эзэлж байна. Тоног төхөөрөмжийг нийлүүлэх салбараар ангилж харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №2 /сая төгрөгөөр/				
№	Салбар	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	Төсөвт эзлэх хувь
1	Төрийн захиргаа	7	555.9	15.8%
2	Байгаль орчин	2	89.0	2.5%
3	Дэд бүтэц, хот байгуулалт	6	347.0	9.9%
4	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	2	1,780.0	50.7%
5	Спорт, соёл урлаг	4	167.5	4.8%
6	Хууль сахиулах, батлан хамгаалах	9	233.4	6.6%
7	Эрүүл мэнд	7	341.2	9.7%
	Нийт	37	3514.0	100

Хүснэгтэд үзүүлсэнчлэн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зориулалтаар тоног төхөөрөмж худалдан авахад хамгийн их санхүүжилтийг баталсан бол байгаль орчныг хамгаалах чиглэлээр тоног төхөөрөмж худалдан авахад хамгийн бага хэмжээний санхүүжилтийг баталсан байна.

Үүнээс төрийн захиргааны үйл ажиллагааг дэмжихэд баталсан 555.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээнүүдээс 455.9 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ нь автомашин, мотоцикл худалдан авах төсөл, арга хэмжээ байгаа бол үлдсэн 100.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ нь төрийн албаны хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн тоног төхөөрөмжийг худалдан авахад чиглэгдсэн бол төрийн үйлчилгээний цахим системийг дэмжихэд чиглэгдээгүй байна.

Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийн төлөвлөлтийн байдалд хяналт хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтын саналыг холбогдох байгууллагуудаас аваагүй, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу эрэмбэлж ажиллаагүй байна.

1.1.3 Дараа онд хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах 1,478.0 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг баталсан байна

Тайлант онд аймаг болон сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах 1,478.0 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг баталсан байна. Үүнээс 460.0 сая төгрөгийн Сайжруулсан эко түлшний үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээ нь ТЭЗҮ/техник эдийн засгийн үндэслэл/ боловсруулах төсөл, арга бол үлдсэн 1,018.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ нь зураг, төсөв боловсруулах төсөл, арга хэмжээнүүд байна. Багцаар задарсан дүнгээр авч үзвэл 37 төсөл, арга хэмжээний зураг төслийг боловсруулахаар хөрөнгө оруулалт баталсан байна.

1.1.4 Төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, заавар журмын дагуу эрэмбэлж төлөвлөөгүй байна.

Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн байдалд хяналт хэрэгжүүлэхэд нийт хэрэгжүүлэхээр төсөл, арга хэмжээнүүдийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, эрэмбэлж төлөвлөөгүй байна.

Тайлант онд төсөл, арга хэмжээний чиглэл, ач холбогдлоор нь авч үзвэл нийгэмд эерэг нөлөө авчрахуйц төсөл, арга хэмжээнүүд байгаа ч хууль журамд заасан шаардлагуудыг хангуулж төлөвлөөгүй, эрэмбэлэх ажлыг огт хийгээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж байгаа нь ирээдүйд хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг бууруулах эрсдэлийг үүсгэж байна.

Хөрөнгө оруулалт нь хөгжлийн жилийн төлөвлөгөөг дэмжээгүй, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоогүй, төрийн үйлчилгээний цахим системийг хөгжүүлэхэд чиглээгүй, хууль, журамд заасан шаардлагуудыг хангуулаагүй, эрэмбэлэлтийг огт хийгээгүй байгаа нь ирээдүйд хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол буурах эрсдэлийг үүсгэж байна.

1.2 Хууль, журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй төсөл, арга хэмжээнүүд баталсан байна.

1.2.1 Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй, олон нийтээр хэлэлцүүлсэн байх шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээнүүдийг баталсан байна.

Төсвийн тухай хууль¹, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх,

¹ 29¹.2.1 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх: барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

хянах, тайлагнах журам”²-д зааснаар төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь тухай шатны ИТХ-аар хэлэлцэгдэхдээ хэрэгжүүлэх ажлын төрлөөс хамаарч техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, магадлалаар баталгаажсан зураг, төсөвтэй байхыг шаарддаг. Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан төсөл, арга хэмжээнүүд нь дээрх шаардлагад нийцсэн эсэхийг хянахад дараах байдалтай байна. Үүнд:

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:

Тайланд онд шинээр буюу үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр баталсан зураг, төсөв шаардах 24,336.6 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээнээс зураг, төсөвгүй 19,609.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 7 төсөл, арга хэмжээг төлөвлөн, баталсан байна. Үүнд:

1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд авто зам дагуу ойн зурвас байгуулах /Мөрөн сум/ - төсөвт өртөг 1,500 сая төгрөг
2. "Ус дулаан дамжуулах төв №11"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажил /Мөрөн сум/ - төсөвт өртөг 2,372.1 сая төгрөг,
3. "Ус дулаан дамжуулах төв №12"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажил /Мөрөн сум/ - төсөвт өртөг 2,500.0 сая төгрөг,
4. "Ус дулаан дамжуулах төв №13"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажил /Мөрөн сум/ - төсөвт өртөг 2,000.0 сая төгрөг,
5. "Ус дулаан дамжуулах төв №11"-ийн 1-р хэлхээний шугам сүлжээг өргөтгөх ажил /төсвийн зөрүү санхүүжилт/ - төсөвт өртөг 887.2 сая төгрөг - төсөвт өртөг 887.2 сая төгрөг,
6. Хүүхэд залуучуудын соёл, амралтын хүрээлэн, гадна тохижилт, жуулчны гудамж байгуулах /Мөрөн сум/ - төсөвт өртөг 9,312.5 сая төгрөг,
7. Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засвар – төсөвт өртөг 1,037.4 сая төгрөг.

Дээрх төсөл, арга хэмжээнүүдийн зураг, төсвийг төсөв батлагдсаны дараа боловсруулан, магадлалаар баталгаажуулсан байна.

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан зураг, төсөв шаардлагатай 2,464.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээнээс 544.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын байрын урсгал засвар төсөл, арга хэмжээнээс бусад төсөл арга хэмжээг зураг, төсөвгүй байхад баталсан байна. Мөн Мөрөн суманд хэрэгжсэн 9 төсөл, арга хэмжээний зураг төсвийг төсөв батлагдсаны дараа боловсруулж төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч зураг, төсвийг магадлалаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.5³-д нийцээгүй байна.

Аймгийн хэмжээнд баталсан орон нутгийн төсвийн нийт хөрөнгө оруулалтыг олон нийтээр хэлэлцүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.2.6⁴-д нийцээгүй байна.

Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлага хангуулж зураг, төсвийг урьдчилан боловсруулж баталгаажуулалгүй ерөнхий төсөөлөл, төсвийн хязгаарт багтаах байдлаар баталж, олон нийтээр хэлэлцүүлэхгүй байгаа нь төсвийн хөрөнгө оруулалт төлөвлөсөн үр дүндээ хүрэхгүй байх, төсөвт өртөг нэмэгдэх, хугацаа хоцрох, чанаргүй хийгдэх зэрэг эрсдэлүүдийг үүсгэж байна.

Төрийн аудитын газраас 2024, 2025 онуудад гүйцэтгэсэн “Хөвсгөл аймгийн орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах”, “Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” аудитуудаар дээрх зөрчилд зөвлөмж, албан шаардлагуудыг хүргүүлж байсан ба 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитын дүнгээс үзэхэд аймгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээ төлөвлөж баталдаг зөрчил **ерөнхийдөө** арилсан байна.

² 3.1.4.5.холбогдох баримт материал, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар

³ Магадлалыг дараахь зураг төсөлд хийнэ: энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

⁴ 29¹.2.6.олон нийтээр хэлэлцүүлсэн байх.

1.2.2 Ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, үнийн судалгаа, тооцоололд үндэслэн ТЭЗҮ, цахим систем, тоног төхөөрөмжийн өртгийг төлөвлөөгүй байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын техникийн тодорхойлолт ажлын даалгавар шаардах 3,487.0 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээнээс 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Тоног төхөөрөмж худалдан авах /Аймгийн ЗДТГ/ төсөл, арга хэмжээнээс бусад 12 төсөл, арга хэмжээ нь төсөв батлагдах үед техникийн тодорхойлолт, ажлын даалгаваргүй байсан байна.

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар техникийн тодорхойлолт, ажлын даалгаваргүй 2,471.2 сая төгрөгийн 74 төсөл, арга хэмжээ баталсан буюу ажлын даалгавар, техникийн тодорхойлолт шаардах бүх төсөл, арга хэмжээг ажлын даалгавар, техникийн тодорхойлолтоггүй баталсан байна.

Ажлын даалгавар, техникийн тодорхойлолтоггүй, ямар тоног төхөөрөмж худалдан авах, ямар ажил хийгдэх нь тодорхойгүй төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөн баталж байгаа нь хөрөнгө оруулалтаар хэрэгцээ шаардлагагүй тоног төхөөрөмж бэлтгэх, ашиглалтад нийцэхгүй тоног төхөөрөмж худалдан авах, төсөвт өртөг хүрэлцэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

1.2.3 Шинээр хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан тэнцүү хуваарилаагүй байна.

Төсвийн тухай хууль⁵д зааснаар төсвийн хөрөнгө оруулалтыг хамгийн ихдээ 3 жилийн хугацаатай, тухайн 3 жилд төсвийг тэнцүү хуваарилан тавьж шилжих хөрөнгө оруулалтыг батлахаар заасан байдаг.

Тайлант сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онд шилжих санхүүжилт бүхий төсөл, арга хэмжээ батлаагүй бол аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар дараах/хүснэгт №3/ төсөл, арга хэмжээнүүдийг баталсан байна.

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа /оноор/		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн	Төсөвт өртөгт эзлэх хувь
		Эхлэх	Дуусах			
1	ОНТХО - Спорт заалны барилга барих /Хөвсгөл, Түнэл сум/	2025	2027	2,156.7	300.0	14%
2	ОНТХО - Иргэдэд үйлчлэх төвийн барилга /Хөвсгөл, Рашаант сум/	2025	2027	2,108.3	300.0	14%
3	Хүүхэд залуучуудын соёл, амралтын хүрээлэн, гадна тохижилт, жуулчны гудамж байгуулах /Мөрөн сум/	2025	2027	9,312.5	450.0	5%
Нийт				13,577.5	1,050.0	

Хүснэгт №3 /сая төгрөгөөр/

Хүснэгтэд үзүүлснээр дээрх 3 төсөл, арга хэмжээний санхүүжилт хэрэгжих онуудад тэнцүү хуваарилаагүй, 2025 онд маш бага хэмжээний санхүүжилтийг баталсан байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хуульд заасан хувь хэмжээгээр хуваарилаагүй байгаа хууль, тогтоомж зөрчигдөх, төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

1.2.4 Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлж төлөвлөөгүй байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийг түвшин, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлж төлөвлөөгүй байна. Төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн байдлыг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд заасан зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлттэй харьцуулахад зорилтод нийцсэн болон

⁵ 29 дүгээр зүйлийн 29.3.5.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;

нийцээгүй бүх төсөл, арга хэмжээний хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлоогүй байна. Жишээ нь:

Хөвсгөл аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний “Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ” зорилтын 7-д заасан “Аж ахуй эрхлэлтийг дэмжих” арга хэмжээнд Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Шаардлагатай сумдад/ төсөл, арга хэмжээ нийцэж байгаа боловч хүрэх шалгуур үзүүлэлтэд заасан 237 иргэний аж ахуй эрхлэлтийг дэмжиж чадсан эсэх нь тодорхойгүй тоног төхөөрөмжүүдийг иргэд, хоршоодод тараасан байдалтай байна.

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлж, төлөвлөсөн зүйл алга байна. Эрдэнэбулган, Мөрөн сумдын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын ажлыг хүрэх дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан ч хөрөнгө оруулалт батлагдсанаас хойших хугацаанд баталсан тул төлөвлөлтийн шатанд хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон гэж үзэх боломжгүй байна.

Төлөвлөлтийн шатанд хүрэх үр дүн нь тодорхойгүй төсөл, арга хэмжээг баталсан нь техникийн тодорхойлолтыг оновчгүй боловсруулах, барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний зураг, төсөвт өөрчлөлт орох, хэрэгжилт удааширах, хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнг үнэлэх боломжгүй байх зэрэг асуудлуудыг үүсгэж байна.

БҮЛЭГ 2:

ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮД БАТАЛСНААС ШАЛТГААЛАН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗАРЛАХ ХУГАЦААГ БАРИМТЛААГҮЙ БАЙНА.

2.1 Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнээс шалтгаалан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан тендер зарлах хугацааг баримталж ажиллаагүй байна.

2.1.1 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулаагүй байна.

Аймаг, сумд нь орон нутгийн төсвийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны төсөв батлах тогтоолын хавсралтаар баталсан байна. Төсвийн тогтоолтой хамтатган баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг зарлах хугацааг нэг өдөр байхаар тооцож баталсан нь худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөсөн гэж үзэх боломжгүй байдалд хүргэж байна. Тухайлбал аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдөр, Эрдэнэбулган сумын төсвийн хөрөнгө хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг 2025 оны дугаар сарын 01-ний өдөр, Мөрөн сумын төсвийн хөрөнгө хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг 2025 оны 02 дугаар сарын 01, 03 дугаар сарын 01-ний өдрүүдэд бөөнөөр нь зарлахаар төлөвлөсөн байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 9 төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан тендер зарлах хугацаанаас 14-60 хоног хүртэл хугацаан хоцроож зарласан бол сумдад мөн адил худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан тендер зарлах хугацаанд тендерийг зарлаагүй байна.

Харин Төрийн хэмнэлтийн тухай хууль⁶д заасны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор худалдан авах ажиллагааг зарлах ерөнхий хугацааг төсвийн тодотголоор нэмэгдсэн төсөл арга хэмжээнүүдээс бусад төсөл, арга хэмжээнүүдэд баримталж ажилласан байна.

2.1.2 Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнүүд төлөвлөн, баталсан нь худалдан авах ажиллагааны хугацаа хоцрох шалтгаан болж байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан тендер зарлах хугацааг баримталж ажиллахгүй байгаа нь зураг, төсөвгүй, ажлын даалгавар, техникийн

⁶ 13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

тодорхойлолтгүй төсөл, арга хэмжээг төлөвлөн баталснаас шалтгаалсан байна. Худалдан авах ажиллагаа явуулах хугацаанд зураг, төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулж байгаа нь хугацаа алдах гол шалтгаан болж байна.

Жишээ нь: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын дэвшилтэд технологи бүхий бие даасан эх үүсвэрээр дулааны шугам сүлжээнд холбох ажлын ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлын худалдан авах ажиллагааны үнэлгээний хороо 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр байгуулагдсан боловч ажлын даалгавар 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр боловсруулагдаж ирснээс шалтгаалан худалдан авах ажиллагааг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зарласан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагаа дуусахгүй байх, хууль зөрчигдөх эрсдэлийг үүсгэж байна.

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа мөн дээрхтэй адил нөхцөл байдалтай байна.

2.1.3 Төсөл, арга хэмжээний онцлог, цар хүрээнд тулгуурлан оролцогчдод тавигдах шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж ажилласан байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулалтын тухайд:

Тендер шалгаруулалтын баримт бичгийг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258 дугаар тушаалаар баталсан “Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан санхүү, техник, туршлагын чадавхын шаардлагуудыг төсөл, арга хэмжээний онцлогт тохируулан тусгаж ажилласан байна. Худалдан авах ажиллагааны баримтад хийсэн хяналтаар төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны оролцогчдод тавих шалгуурыг хэт доогуур тавьсан худалдан авах ажиллагаа байхгүй байна.

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулалтын тухайд:

Аудитад хамруулан шалгасан сумд нь мөн Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258 дугаар тушаалаар баталсан “Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж баталгаажуулж ажилласан байна. Харин Эрдэнэбулган сумын хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны баримтад хяналт хэрэгжүүлэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Бетон зуурагч тоног төхөөрөмж худалдан авах, Цемент худалдан авах, МУЗГ-ын 2024-2027 онд хэрэгжүүлэх эрүүл мэнд шүд хөтөлбөрийн хүрээнд СӨБ, ЕБС-ийн бүх сурагч хүүхдүүдийг сүүгээр хангах 3 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын баримт бичгийг сумын Засаг дарга баталгаажуулж ажиллаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална." гэж заасантай нийцээгүй,
2. Зарим тендер шалгаруулалтын хувийн хэргийг бүрдүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 48 дугаар зүйлийн 48.5-д "Тендер шалгаруулалтын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална." гэж заасантай нийцэхгүй байна.

Дээр дурдсан зөрчлийг эс тооцвол сумд нь төсөл, арга хэмжээний оролцогчдод хууль, журамд заасан тавигдах шаардлагуудыг тендерийн баримт бичгүүдэд тусгаж ажилласан байна.

2.1.4 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангахгүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны тухайд:

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 онд шинээр болон үргэлжлэн хэрэгжих 27,853.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа явуулж 37 гүйцэтгэгчтэй 26,307.9 сая төгрөгийн гэрээ байгуулан 820.8 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гаргасан байна. Худалдан авах ажиллагааны нээлттэй тендер шалгаруулалтын аргыг 27,566.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээ, харьцуулалтын тендер шалгаруулалтын аргыг 287.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээнд ашигласан байна.

Худалдан авах ажиллагаанд хийсэн хяналтаар дараах 1 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэхгүй гүйцэтгэгч шалгаруулсан зөрчил илэрлээ. Үүнд:

Ус дулаан дамжуулах төв №11-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр ижил төстэй 2 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгчээр шалгарсан, төсөл, арга хэмжээнд ажиллах инженер техникийн ажилчид болон техник тоног, төхөөрөмж нь давхцаж байгаа Бат комплект ХХК/Дулаан хаан констракшн ХХК-тай түншлэлийн гэрээтэй/-ийг шалгаруулсан байна.

Энэ нь Ус дулаан дамжуулах төв №11, 12, 13-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох төсөл, арга хэмжээнүүдийн тендер шалгаруулалтын баримт бичгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 35.1-д "Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхцсан эсэхийг дахин магадална", Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-т заасан "Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: "Шаардана" а) Тендерт санал болгосон инженер техникийн ажилтнуудын 30-аас дээш хувь нь одоо хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан дуусаагүй ажилд давхцсан тохиолдолд татгалзана.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.4-т "Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ: тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага хангасан байх" гэж заасантай нийцээгүй байна.

Бусад төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангасан оролцогчийг гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж ажилласан байна.

Сумдын хөрөнгө оруулалтын тухайд:

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт баталсан 5 сумдын ЗДТГ-аас 3,124.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 50 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зарлаж 78 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж 224.8 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гаргасан байна. Худалдан авах ажиллагааны нээлттэй тендер шалгаруулалтын аргыг 1,586.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээнд, 943.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл арга хэмжээнд ашигласан бол 595.2 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээнд ашигласан байна.

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын дийлэнх төсөл, арга хэмжээнүүд нь төсөвт өртгийн хувьд бага шууд худалдан авалт боломжтой төсөл, арга хэмжээнүүд байна. Нээлттэй болон харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагаа зохион байгуулсан худалдан авалтуудад хяналт хэрэгжүүлэхэд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангасан оролцогчийг гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж ажилласан байна.

Тендерийн баримт бичгийг хууль, журамд заасны дагуу боловсруулсан, худалдан авалттай холбоотой зөрчил бага гарсан боловч төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний зураг, төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын боловсруулалтаас шалтгаалан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацааг баримтлахгүй байх, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчигдөх, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч шалгараагүйн улмаас төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэл байсаар байна.

2.2. Сангийн яам тендер шалгаруулалтад гаргасан гомдлыг хянасан шийдвэрийн дагуу Үнэлгээний хороод нь дахин үнэлгээ хийж гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулсан байна.

Тайлант онд аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтын дараах 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол гарч Сангийн яам хянасан байна. Үүнд:

1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд авто зам дагуу ойн зурвас байгуулах /Мөрөн сум/
2. Хөвсгөл Ус суваг ХХК-ийн эзэмшлийн төв халуун усны халаалтын зуух, УДДТ-11, УДДТ-12, УДДТ-13 хэрэглэгчдийг нэмж холбох зураг төсөв боловсруулах
3. Мөрөн сумын ЗДТГ-ын Брэндбүүк бүтээх (зөвлөх үйлчилгээ)
4. Гамшгийн бэлэн байдлыг хангах зорилгоор бараа материал хадгалах контейнер худалдан авах
5. Эрдэнэ булган сумын ЗДТГ-т Бетон зуурагч тоног төхөөрөмж худалдан авах

Дээрх төсөл, арга хэмжээнүүдийн мэдэгдэл хүргүүлсэн хугацаа, тендер шалгаруулалтыг түдгэлзүүлж, баримт, материал татан авсан хугацаа болон худалдан авах ажиллагаанд гарсан гомдлыг хянаж хариу ирүүлсэн хугацаа зэргээс үзэхэд Сангийн яам нь гомдлыг хуулийн хугацаа⁷нд хянаж шийдвэрлэсэн байна.

Үнэлгээний хороо нь Сангийн яамны гомдол хянасан шийдвэрийг үндэслэн дахин үнэлгээг хийж ажилласан ба дахин үнэлгээний шийдвэрт гомдол гарсан тохиолдол байхгүй байна.

Тайлант онд аймгийн Худалдан авах ажиллагааны газар болон сумдын ЗДТГ-ын цахим системийн бүртгэл, мэдээлэлд эрх бүхий байгууллагаас хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тохиолдол байхгүй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг Сангийн яамнаас хуульд заасан хугацаанд хянаж, үнэлгээний хороод нь дахин үнэлгээг хийж ажилласан бол аймгийн Худалдан авах ажиллагааны газар болон сумдын ЗДТГ-ын цахим системийн бүртгэл, мэдээлэлд эрх бүхий байгууллагаас хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байгаа нь худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалтын талаар мэдээлэл авах боломжийг хязгаарлаж байна.

БҮЛЭГ 3:

ЗОХИОГЧ, ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ АЖИЛЛАЖ, ХЯНАЛТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ЗААСАН ХУГАЦААНД НЬ ГҮЙЦЭТГҮҮЛЖ ЧАДАХГҮЙ БАЙГААГААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛСААР БАЙНА.

3.1 Зарим төсөл, арга хэмжээг зураг, төсөв гэрээнд заасан хугацааг гүйцэтгүүлээгүй байна.

3.1.1 Аймгийн хэмжээнд хэрэгжсэн нийт төсөл, арга хэмжээнүүдийн 53 хувь төлөвлөсөн хугацаанд хэрэгжсэн байна.

Аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр баталсан 122 төсөл, арга хэмжээнээс 65 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссан бол 17 төсөл, арга хэмжээ хэрэгжилт дутуу, 37 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 3 төсөл, арга хэмжээ тодотголоор хасагдсан байна. /төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийг хавсралт №2-оос харна уу/

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр баталсан болон гэрээнд заасан хугацаанд хэрэгжүүлсэн эсэхэд хяналт хэрэгжүүлэхэд дараах байдалтай байна. Үүнд:

⁷ 59.8 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендер шалгаруулалтад холбоотой цахим системд байршуулсан баримт бичиг, мэдээлэл, тендер шалгаруулалтын хувийн хэрэгт үндэслэн гомдлын үндэслэлийн хүрээнд ажлын 10 өдөрт багтаан гомдлыг хянан шийдвэрлэнэ.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан 28 төсөл, арга хэмжээнээс 9,579.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссан байна. Үүнээс 1,629.4 төсөл, арга хэмжээ өмнөх онуудад хэрэгжиж дууссан ба тайлант онд үлдэгдэл санхүүжилтийг олгохоор баталсан байна.

Хэрэгжилт дутуу төсөл, арга хэмжээнүүдээс 15,949.7 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ нь хэрэгжүүлэх хугацаа, гэрээний заасан хугацааны дагуу дутуу гүйцэтгэлтэй байгаа бол 4,850.0 сая төгрөгийг дараах 4 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд дуусаагүй хэрэгжилт дутуу байна.

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Хугацаа		Санхүүжилт		Гүйцэтгэл /хувиар/
			Эхлэх	Дуусах	Олгох	Олгосон	
1	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд төрийн албан хаагчдын орон сууцны засвар, өргөтгөл хийх	50.0	2023	2025	10.0	-	80
2	Дэвшилтэд технологи бүхий бие даасан эх үүсвэрээр дулааны шугам сүлжээнд холбох ажлын ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах	300.0	2025	2025	300.0	120.0	40
3	"Ус дулаан дамжуулах төв №12"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажил /Мөрөн сум/	2,500.0	2025	2025	2,500.0	809.8	70
4	"Ус дулаан дамжуулах төв №13"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажил /Мөрөн сум/	2,000.0	2025	2025	2,000.0	900.6	80
Нийт		4,850.0			4,810.0	1,830.4	

Хүснэгтэд үзүүлснээр төсөл, арга хэмжээнүүд нь бүрэн санхүүжилттэй байхад гүйцэтгэгч нь ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, захиалагч гэрээний хугацаанд гүйцэтгүүлж ажиллаагүй байна.

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан 94 төсөл, арга хэмжээнээс 45 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссан бол 9 төсөл, арга хэмжээ хэрэгжилт дутуу, 40 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Хэрэгжээгүй 40 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл, арга хэмжээ нь төсвийн тодотголоор хасагдсан, 30 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн эх үүсвэр хууль зөрчсөн үндэслэлээр зогсоосон, 2 төсөл, арга хэмжээ гэрээ байгуулсан боловч тайлант онд хэрэгжээгүй бол 5 төсөл, арга хэмжээг захиалагч тодорхой шалтгаангүйгээр хэрэгжүүлээгүй байна.

Хэрэгжилт дутуу 9 төсөл, арга хэмжээний хувьд 1 төсөл, арга хэмжээг дараа онд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан бол 1 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт татагдсанаас дутуу хэрэгжсэн, үлдсэн 7 төсөл, арга хэмжээг тодорхой шалтгаангүйгээр бүрэн хэрэгжээгүй захиалагч энэ талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Аймаг, сумдын төсвийн хөрөнгөө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдээс 20 төсөл, арга хэмжээ төсвийн тогтоолоор баталсан хугацаа болон гэрээний хугацаанд хэрэгжээгүй байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хугацаанд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

3.1.2 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Тайлант онд аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдэд гэрээ байгуулсан 84 төсөл, арга хэмжээнээс 74 төсөл, арга хэмжээнд 10,977.5 сая төгрөгийн төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнээс аймгийн төсвийн хөрөнгө оруулалтад 8,801.7 сая төгрөгийн санхүүжилт, сумдын төсвийн хөрөнгө оруулалтад 2,175.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 2025 оны 10 дугаар сараас хойш хязгаарласны улмаас 4 төсөл, арга хэмжээний 2,621.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй бол зарим сумдын хөрөнгө оруулалтын санхүүжилт олгогдоогүй байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл болон гүйцэтгэлд олгосон санхүүжилтэд хяналт хэрэгжүүлэхэд төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна. Харин дараах 2 төсөл, арга хэмжээний гэрээнд санхүүжилтээс суутгахаар заасан нормчлолын сангийн шимтгэл 3.0 сая төгрөгийг суутган авч үлдээгүй байна. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засвар – 0.9 сая төгрөг,
2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд авто зам дагуу ойн зурвас байгуулах /Мөрөн сум/ - 2,1 сая төгрөг. Зөрчилд нормчлолын сангийн шимтгэлийг буцаан төвлөрүүлэх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3.1.3 Зарим төсөл, арга хэмжээг зураг, төсвийн дагуу гүйцэтгүүлээгүй байна.

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэхэд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн дараах төсөл, арга хэмжээнүүдийг зураг, төсвөөс зөрүүтэй гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. "Ус дулаан дамжуулах төв №11"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох төсөл, арга хэмжээний зохиогчийн хяналтын дүгнэлтээр дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

1. ДХ-28, 29, 31-р худгуудыг зураг, төсөвт заасан хэмжээнээс багасган цутгасан. Худгийн түвшин алдагдсан.
2. Шугамын дулаалга чанар муутай хийгдсэн.
3. Бетон дэр, гулсах тулгуур буруу хийгдсэн.
4. Төмөр бетон сувгуудын хоорондын чигжээс хийгдээгүй.
5. Захын дундуур явсан өөрчлөгдсөн трасс цэвэр, бохир усны шугамтай хэт ойртсон.

2. "Ус дулаан дамжуулах төв №12"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох төсөл, арга хэмжээний зохиогчийн хяналтын дүгнэлтээр дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

1. ДХ-37-с ДХ-48 хүртэл, ДХ-49-с ДХ-50 хүртэл 13ш худгийг 1,85х1,85м хэмжээтэйгээр ханын зузааныг 300мм болгож багасгаж цутгасан.
2. ДХ-13-с ДХ-16, ДХ-29-с ДХ-30 хүртэл 6ш худгийг 2,3х2,3м хэмжээтэйгээр ханын зузааныг 300мм болгож багасгаж цутгасан.
3. ДХ-41-с ДХ-46 хүртэл суваг худгийн улны түвшин алдагдсан.
4. ДХ-37-с ДХ-38 хүртэл сувгийн хэмжээг нарийсгасан.

3. "Ус дулаан дамжуулах төв №13"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох төсөл, арга хэмжээний зохиогчийн хяналтын дүгнэлтээр дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

1. Зө-3, ҮХТ-4-н байрлал буруу.
2. Дулаалга пенополиуретаны чанар муу.
3. Бүх гулсах тулуур бетон дэрийг шалгаж зөв болгож зохист зайнд болгон тааруулах. Гулсах тулгуур буруу. 2 талд нь полоса төмөр гагнахгүй бол трубагаа цоолох аюултай.
4. ДХ-36-н дээд дам нурууг буруу цутгасан.

Төсөл, арга хэмжээнүүдийг Бат комплект ХХК, Дулаан хаан констракшн ХХК-тай хамтран гүйцэтгэж байгаа бөгөөд зохиогчийн зүгээс тавьсан шаардлагыг хэрэгжүүлээгүй, захиалагчийн хяналтаас зураг төсвийн дагуу гүйцэтгүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна. Дээрх зөрчилд захиалагчийн хяналтын төвд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Аймгийн төсвийн бусад төсөл, арга хэмжээний зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгүүлсэн ба техникийн тодорхойлолтод нийцээгүй тоног төхөөрөмж нийлүүлсэн 1 төсөл, арга хэмжээний санхүүжилтээс 4.0 сая төгрөгийг хасаж олгосон байна.

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Аюултай хог хаягдал шатаах зуух худалдан авах төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн шатаах зуухны гадна хамгаалалт нь халалтыг тэсвэрлэхгүй

салж унасан байдалтай байгаа нь ашиглалтын шаардлагад нийцэхгүй материалаар хийсэн болохыг харуулж байна.



Зураг 1. Аюултай хог хаягдал шатаах зуухны гадна хамгаалалт хуурч унасан байдал

Харин бусад төсөл, арга хэмжээний хувьд зураг, төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасны дагуу гүйцэтгүүлсэн байна.

3.1.4 Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлээгүй, гэрээний хугацаанд ажлыг гүйцэтгүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:

Тайлант онд хэрэгжиж дууссан аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн сүүлийн санхүүжилтийг олгохдоо гэрээг дүгнэж ажилласан байна. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг дүгнэхдээ гэрээний хугацаа хэтэрсэн, 2 төсөл, арга хэмжээнд 1.7 сая төгрөгийн алданги тооцож ажилласан байна.

Харин дараах 4,597.4 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээнүүдийг гэрээнд заасан хугацаа болон 2025 онд багтаан гүйцэтгүүлээгүй, гэрээний хэрэгжилтийн байдалд үнэлж ажиллаагүй байна. Үүнд:

1. "Ус дулаан дамжуулах төв №12"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох
2. "Ус дулаан дамжуулах төв №13"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох
3. Дэвшилтэд технологи бүхий бие даасан эх үүсвэрээр дулааны шугам сүлжээнд холбох ажлын ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах - багц 1 - Дэвшилтэд технологи бүхий бие даасан эх үүсвэрээр дулааны шугам сүлжээнд холбох /Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Зүүн мөрөн хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан инженерийн шугам сүлжээ/ ажлын зураг төсөл боловсруулах,
4. Дэвшилтэд технологи бүхий бие даасан эх үүсвэрээр дулааны шугам сүлжээнд холбох ажлын ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах - багц 2 - Дэвшилтэд технологи бүхий бие даасан эх үүсвэрээр дулааны шугам сүлжээнд холбох /Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Зүүн мөрөн хорооллын 14МВТ-ийн дулааны станц/ ажлын зураг төсөл боловсруулах.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.3.2-т "Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4-т заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр

авч ажиллана;" гэж заасантай нийцээгүй байна. Дээрх зөрчилд алданги тооцож ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Бусад төсөл, арга хэмжээнүүдийн хувьд гэрээний гэрээний хэрэгжилтийг үнэлж гэрээг ажилласан байна.

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн гэрээ дүгнэсэн байдалд хяналт хэрэгжүүлэхэд Эрдэнэбулган суманд хэрэгжсэн Цагдаагийн кобанд дулааны дотоод шугам сүлжээ холбох төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа хэтэрсэн 33 хоногт ноогдох 145,200 төгрөгийн алданги, Хил хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа хэтэрсэн 44 хоногт ноогдох 440,000 төгрөгийн алданги нийт 585,200 төгрөгийн алданги суутгаагүй байна.

Энэ нь тус ажлуудыг гүйцэтгэх Гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 10.22, ГЕН 4.17 дахь заалтуудад "хоног тутамд 0.1 хувиар тооцож тогтооно" гэж заасантай нийцэхгүй байна. Зөрчлийг давтан гаргахгүй зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Харин бусад төсөл, арга хэмжээний хувьд гэрээний хэрэгжилтийг үнэлж, гэрээг дүгнэж ажилласан байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгож ажилласан ч, нийт төсөл, арга хэмжээний 47 хувь нь хэрэгжээгүй, зарим төсөл, арга хэмжээг зураг төсвийн гүйцэтгүүлээгүй, хугацаа хоцорсон төсөл, арга хэмжээнүүдийн гэрээний хэрэгжилтийг үнэлж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байгаа нь төсөл, арга хэмжээний гэрээний хариуцлагыг тухай бүр тооцож ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

3.2 Захиалагчийн хяналт хангалтгүй ажиллаж, хяналтын ажлын үр нөлөөг бууруулж байна.

3.2.1 Зохиогч, захиалагч хяналт нь хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар үр нөлөөтэй ажиллаагүй байна.

Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримтад хийсэн хяналтаар төсөл, арга хэмжээний гүйцэтгэлүүдэд зохиогч болон захиалагч хяналт хэрэгжүүлж дүгнэлтүүд гаргаж ажилласан байна.

Өмнөх онуудтай харьцуулахад аймгийн төсвийн болон Мөрөн сумын төсвийн төсвийн хөрөнгө оруулалтын зураг, төсөв зохиогчид нь зохиогчийн хяналтыг сайн хэрэгжүүлж зураг, төсөвт орсон өөрчлөлтийг тооцож, төсвийн зөрүү үүсэх эсэх талаар дүгнэлт гаргаж, гарсан зөрчлийг арилгуулах талаар шаардлага өгч ажилласан байна. Харин Ус дулаан дамжуулах төв №11,12, 13"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох" төсөл, арга хэмжээнүүдийн зохиогч нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хийсэн хяналтаар илэрсэн зөрчилд өгсөн шаардлагынхаа биелэлтийг тооцож, зөрчлийг арилгуулж чадаагүй байгаа нь зохиогчийн хяналтын үр дүнг бууруулж байна.

Захиалагчийн хяналтын тухайд төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тухай бүр дүгнэлт гаргаж ажилласан ч захиалагчийн хяналтын дүгнэлтүүдэд гүйцэтгэлийн үе шатны ерөнхий мэдээллийг тусгаад гүйцэтгэлийн явцад зохих шаардлагуудыг тавьж засуулсан гэж байдлаар дүгнэлтийг гаргаж байгаа нь туйлын хангалтгүй хяналтыг хэрэгжүүлж байгааг харуулж байна. Тухайлбал дээр дурдсан төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийн явцад зохиогчийн хяналтаар хэд, хэдэн алдаа зөрчлийг илрүүлж, шаардлага өгсөн байхад захиалагчийн хяналтын зүгээс барилгын ажил хэвийн үргэлжилж байна гэж дүгнэсэн байгаа нь захиалагчийн хяналт үр нөлөөтэй ажиллаж чадахгүй байгааг харуулж байна.

Бусад сумдын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд зохиогчийн болон захиалагчийн хяналт шаардахгүй төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна.

3.2.2 Барилга байгууламжийн бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандарт, заслын ажлын материалын шаардлагад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Барилга захиалагчийн хяналтын төвийн дүгнэлтүүдээс үзэхэд захиалагчийн хяналт нь барилгын ажлын бетоны бат бэхийн үзүүлэлт, материалын чанарын байдлыг

дүгнэлтүүддээ огт тусгаагүй, бетоны бат бэх, материалын шаардлагад хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2.3 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд комисс заавар журмын дагуу хяналт тавьж ашиглалтад хүлээн авсан байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын барилга байгууламж, засварын ажилд аймгийн Засаг даргаас байгуулсан улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан бол тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээг ажлын хэсэг хүлээн авсан байна.

Сумдын тухайд сумын Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг ажлуудыг хүлээн авсан байна.

Тайлант онд дараах барилга байгууламжийн, 3,245.5 сая төгрөгийн дараах 4 төсөл, арга хэмжээг аймгийн улсын комисс ашиглалтад хүлээн авсан байна. Үүнд:

1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд авто зам дагуу ойн зурвас байгуулах /Мөрөн сум/ - гэрээний дүн 1,350.7 сая төгрөг,
2. Нэгдсэн эмнэлгийн гадна авто машины зогсоол байгуулах /Мөрөн сум/ - гэрээний дүн 482.8 сая төгрөг,
3. "Ус дулаан дамжуулах төв №11"-ийн 1-р хэлхээний шугам сүлжээг өргөтгөх ажил /төсвийн зөрүү санхүүжилт/ - гэрээний дүн 600.0 сая төгрөг,
4. Мөрөн сумын төвлөрсөн хогийн цэгт нөхөн сэргээлт хийх – гэрээний дүн 812.0 сая төгрөг.

Улсын комисс нь төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авахдаа холбогдох үүрэг, даалгавруудыг өгч биелэлтийг тооцож хүлээн авсан байна.

Бусад хэрэгжиж дууссан 41 төсөл, арга хэмжээг аймаг, сумдаас байгуулсан ажлын хэсэг ажиллаж хүлээн авсан байна.

3.2.4 Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хийсэн хяналтаар аймаг болон сумдын хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилга байгууламжийн нийт төсөл, арга хэмжээнүүдэд мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулаагүй байна. Энэ Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 107 дугаар тушаалаар баталсан “Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт БНБД 12-01-09”-ын 7.8⁸-д нийцээгүй байна.

Тайлант онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлтэй холбоотой зөрчил гараагүй, улсын комисс ажиллан хүлээж авсан байгаа боловч хэрэгжилт дутуу зарим төсөл, арга хэмжээний зохиогч болон захиалагчийн хяналт нь илрүүлсэн зөрчлүүдээ арилгуулж чадаагүй, бетоны бат бэх, заслын ажлын материалын шаардлагад хяналт хэрэгжүүлж дүгнэлт гаргаагүй байгаа нь зохиогч болон захиалагчийн хяналтын үр нөлөөг илүү сайжруулах шаардлагатай болохыг харуулж байна.

3.3 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 1,367.8 сая төгрөгийг хөрөнгийг бүртгээгүй, Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Шаардлагатай сумдад/ төсөл, арга хэмжээний үр дүнг тодорхойлох боломжгүй байна.

3.3.1 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 1,367.8 сая төгрөгийг хөрөнгийг бүртгээгүй, Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Шаардлагатай сумдад/ төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг бүрэн тодорхойлох боломжгүй байна.

⁸ Барилгын талбайн гол хаалганы дээр тусгай самбар байрлуулж түүнд объектын нэр, захиалагч /хөрөнгө оруулагч/ ба гүйцэтгэгчийн нэр, уг барилгын даамал, зөвлөх болон мэргэжлийн хяналтын байгууллагаас уг объектын хариуцагч хяналтын байцаагчийн нэр, харилцах утас, барилга эхлэх, дуусах хугацааг томоор заавал бичсэн байх ёстой. Бичвэр нь гудамжны хөдөлгөөнд оролцогсдод саадгүй уншигдах хэмжээнд байна.

Тайлант онд хэрэгжиж дууссан 65 төсөл, арга хэмжээнээс 45 төсөл, арга хэмжээний 5.871.5 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгасан бол 1,367.8 сая төгрөгийн дараах 4 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

1. Хөвсгөл Ус суваг ХХК-ийн эзэмшлийн төв халуун усны халаалтын зуух, УДДТ-11, УДДТ-12, УДДТ-13 хэрэглэгчдийг нэмж холбох зураг төсөв боловсруулах – 270.0 сая төгрөг,
2. Нэгдсэн эмнэлгийн гадна авто машины зогсоол байгуулах /Мөрөн сум/ - 482.8 сая төгрөг,
3. "Ус дулаан дамжуулах төв №11"-ийн 1-р хэлхээний шугам сүлжээг өргөтгөх ажил /төсвийн зөрүү санхүүжилт/ - 600.0 сая төгрөг,
4. Эрдэнэбулган сумын төсвийн хөрөнгө оруулалтын Зөвлөх үйлчилгээний хийгдсэн зураг төсөв, – 15.0 сая төгрөг.

Харин өмчлөл бий болгохгүй 1,634.8 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгаагүй байна.

Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн хуваарилалт, ашиглалтын байдалд хяналт хэрэгжүүлэхэд дараах асуудлууд илэрч байна. Үүнд:

1. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Шаардлагатай сумдад/ төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 138 нэр төрлийн 1,538.2 сая төгрөгийн үнэ бүхий 739 тоног төхөөрөмжийг сумдын ЗДТГ-т шилжүүлж, иргэдэд гэрээгээр ашиглуулахдаа түрээсэлж байгаа эсэх, худалдаж байгаа эсэх нь тодорхойгүй гэрээний загварыг сумдад хүргүүлж гэрээ хийлгэсэн байна. Иргэд 3 жил гэрээний дагуу хөрөнгийг ашигласны дараа тухайн хөрөнгийг хэрхэх тухай мөн гэрээгээр зохицуулаагүй байна.
2. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Шаардлагатай сумдад/ төсөл, арга хэмжээний хүрээнд авсан багц төхөөрөмжүүдийг нэг бүрчлэн тараасан нь төсөл, арга хэмжээний үр ашгийг бууруулж байна. Тухайлбал: Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж - Бетон зуурмагийн тоног төхөөрөмж төсөл, арга хэмжээний хэв, блокийн төхөөрөмжүүдийг авто замын болон явган замын бродюрын хэв, явган замын хавтангийн хэвүүдийг Ханх сумын ЗДТГ-т шилжүүлсэн бол Бетон зуурмагийн машиныг нь Их-Уул суманд шилжүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын ашиглалтын чиглэлийг аймгийн ИТХ, Засаг даргаас тодорхойлж өгөөгүйн улмаас өрхийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг иргэдэд хэрхэн ашиглуулах нь тодорхойгүй, оновчгүй хуваарилалт хийгдсэн байна. Энэ нь Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.1.10-т Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх,” гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн хэвшлийн байгууллагуудад хуваарилсан хөрөнгийн ашиглалтад хяналт хэрэгжүүлэхэд зориулалтын дагуу ашиглаж байгаа бол иргэд, хоршоодод тараасан тоног төхөөрөмжийн ашиглалтыг тодорхойлох боломжгүй байна.

3.3.2 Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, тайлагнаагүй байна.

Тайлангийн 1.2.4 дэх хэсэгт дурдсанаар тайлант онд аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан нийт төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилт, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг хангалттай хэмжээнд тооцоогүй байна. Мөн холбогдох байгууллагуудаас ирүүлсэн баримтаас үзэхэд бодлогын зорилтын үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан тайлагнаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.1.11-т Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: төсвийн хөрөнгө оруулалтын тайлан, үр дүн, үр ашгийг тооцох,...” гэж заасантай нийцээгүй байна.

3.3.3 Хөвсгөл аймгийн хэмжээнд хэрэгжсэн нийт төсөл, арга хэмжээний 51 хувь нь бодлогын зорилтот үр дүнд хүрсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг аймаг, сумаар ангилан хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №5

д/д	Төсвийн ангилал	Баталсан төсөл, арга хэмжээний тоо	Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тоо	Хувь
1	Аймаг	28	24	85%
2	Алаг-Эрдэнэ сум	1	1	100%
3	Их-Уул сум	3	3	100%
4	Цагаан-Уул сум	12	6	50%
5	Эрдэнэбулган сум	51	10	19%
6	Мөрөн сум	27	26	96%
	Нийт	94	65	Дундаж хувь 75%

Хүснэгтэд үзүүлснээр аймгийн хэмжээнд хэрэгжсэн нийт төсөл, арга хэмжээний дундаж гүйцэтгэл 75 хувь төлөвлөсөн үр дүнд хүрсэн бол аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 85 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

Харин бодлогын зорилтот үр дүнд хүрсэн эсэхийг дээрх хувиар илэрхийлэх боломжгүй байна. Тайлангийн 1.1.1 дэх хэсэгт дурдсанаар аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 16,251.6 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ нь 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцээгүй, бодлогын зорилтот нийцсэн боловч Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /шаардлагатай сумдад/ төсөл, арга хэмжээний үр дүнг тооцох боломжгүй байгаа тул аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 13 төсөл, арга хэмжээ буюу 46 хувь нь бодлогын зорилтот үр дүнд хүрсэн байна.

Харин Мөрөн сумын тухайд 1 төсөл, арга хэмжээ бодлогын зорилтод нийцээгүй, 1 төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй тул бодлогын зорилтот үр дүнд хүрсэн байдлыг 92 хувиар үнэлэх боломжтой байна.

Алаг-Эрдэнэ сумын хөрөнгө оруулалтын тухайд баталсан 1 төсөл, арга хэмжээ нь 5 жилийн үндсэн чиглэлд нийцээгүй бодлогын зорилтот үр дүнд хүрсэн гэж үнэлэх боломжгүй байна.

Их-Уул, Цагаан-Уул, Эрдэнэбулган сумдын хөрөнгө оруулалтын тухайд бодлогын зорилтот үр дүнг хүснэгтэд үзүүлснээр тооцох боломжтой байна.

Дээрх дүнгээр бодлогын зорилтот үр дүнд хүрсэн байдлыг үнэлбэл аймгийн хэмжээнд хэрэгжсэн нийт төсөл, арга хэмжээний 51 хувь нь бодлогын зорилтот үр дүнд хүрсэн байна.

3.3.4 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

Өмнөх онд гүйцэтгэсэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээ төлөвлөн, батлах 2 албан шаардлага, 18 зөвлөмжийг 8 байгууллага, албан тушаалтанд өгч хэрэгжилтийн биелэлтийг авч тооцож ажилласан. Аймгийн ИТХ, Засаг даргад өгсөн албан шаардлага нь орон нутгийн төсвийн 2026 оны төсөлд дүгнэлт гаргах аудитын дүнгээс харахад хангалттай хэрэгжсэн бол зөвлөмжийн хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №6

№	Зөвлөмж авсан албан тушаалтан		Зөвлөмжийн утга	Хэрэгжилт /хангалттай, дунд, хангалтгүй/
1	Аймгийн Засаг дарга	1	Өмчлөлд бүртгэх боломжгүй, урсгал зардлын шинжтэй төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагын төсөвт шилжүүлэн батлуулж байх.	хангалттай
		2	Захиалагчийн болон зохиогчийн хяналтын үр нөлөөг сайжруулж, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх	дунд
2	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт,	3	Гэрээний хугацаа хэтэрсэн Сумын төвд нэгдсэн халаалт холбох байгууллагын дотоод сантехникийн	хангалттай

	бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга		их засвар /Эрдэнэбулган сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид алданги тооцох	
3	Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	4	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хууль, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу төлөвлөсөн эсэхэд хяналт хэрэгжүүлж, хурлаар хэлэлцүүлэх	хангалтгүй
4	Мөрөн сумын Засаг дарга	5	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хууль, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу төлөвлөж, олон нийтээр хэлэлцүүлж байх,	хангалтгүй
		6	Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах.	хангалттай
		7	Өмчлөлд бүртгэх боломжгүй, урсгал зардлын шинжтэй төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагын төсөвт шилжүүлэн батлуулж байх	хангалтгүй
		8	Худалдан авах ажиллагааны тендерийн хүчинтэй хугацаанд гэрээ байгуулж ажиллах,	хангалттай
		9	Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон тендерийн хэмнэлтийг зарцуулахгүй байх.	хангалтгүй
		10	Мөрөн сумын 10, 13, 14 дүгээр багуудын гэрлэн хаяг төсөл, арга хэмжээний гэрээнд заасан барьцаа хөрөнгө 0.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, гэрээний дагуу чөлөөлөх	хангалттай
5	Орон нутгийн өмчийн газрын дарга	11	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах ажлыг шуурхай зохион байгуулж, хяналтыг хэрэгжүүлэх	хангалттай
6	Хөвсгөл аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга	12	Тендер шалгаруулалтын баримт бичгийг баталгаажуулж ажиллах,	хангалттай
		13	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, төлөвлөгөөг баримталж ажиллах,	хангалтгүй
		14	Захиалагч болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдлыг бодитоор үнэлж байж санхүүжилтийг олгох	дунд
7	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга	15	Төсөл, арга хэмжээний зураг, төсөв, ажлын иж бүрэн байдалд хяналт хэрэгжүүлж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулахад анхаарч ажиллах	дунд
8	Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын захирал	16	Тайланд дурдсан төсөл, арга хэмжээнүүдийн дутуу болон хангалтгүй хийгдсэн ажлуудыг гүйцэтгүүлж, захиалагчийн хяналтын үр нөлөөг сайжруулах,	дунд
		17	Захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгчийн хувьд зохиогчийн хяналтыг үр нөлөөтэй болгох арга хэмжээ авах,	дунд
		18	Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын дутуу орон тоог нөхөж ажиллах	хангалттай

Хүснэгтэд үзүүлснээр 8 зөвлөмжийг хангалттай түвшинд хэрэгжүүлсэн бол 5 зөвлөмжийг дунд, 5 зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Аудитын дүн, илэрч буй зөрчлийн байдлаар өмнөх оны аудитаар өгсөн 2 албан шаардлага, 18 зөвлөмжийн биелэлтийг дүгнэвэл 75 хувь нь тодорхой үр дүнд хүрч зөрчил тодорхой хэмжээнд багассан байна. Худалдан авах ажиллагаа, санхүүжилттэй холбоотой зөрчил багассан бол төлөвлөлт, хяналт, өмч бүртгэл, ашиглалттай холбоотой зөрчил байсаар байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 1,367.8 сая төгрөгийг хөрөнгийг бүртгээгүй, Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Шаардлагатай сумдад/ төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг бүрэн тодорхойлох боломжгүй, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, бодлогын зорилтын үр дүнд хүрсэн эсэхийг

харьцуулан тайлагнаагүй байгаа нь хөрөнгийн ашиглалт, хөрөнгө оруулалтын үр нөлөөг
бууруулж байна.

**Аудитаар нийт 8,242.9 сая төгрөгийн зөрчил илэрч, 6,872.1 сая төгрөгийн 1
албан шаардлага, 1,370.8 сая төгрөгийн 20 зөвлөмжийг холбогдох 8 байгууллага,
албан тушаалтанд хүргүүлж ажиллалаа.**

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Зарим төсөл, арга хэмжээнүүд нь хөгжлийн жилийн төлөвлөгөөг дэмжээгүй, нийт төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоогүй, төрийн үйлчилгээний цахим системийг хөгжүүлэхэд чиглээгүй, хууль, журамд заасан шаардлагуудыг хангуулаагүй, эрэмбэлэлтийг огт хийгээгүй байгаа нь ирээдүйд хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол буурах эрсдэлийг дагуулж болзошгүй байна.
2. Төлөвлөлтийн шатанд хүрэх үр дүн нь тодорхойгүй төсөл, арга хэмжээг баталсан нь техникийн тодорхойлолтыг оновчгүй боловсруулах, барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний зураг төсөвт өөрчлөлт орох, хэрэгжилт удаашрах, хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнг үнэлэх боломжгүй байх зэрэг асуудлуудыг үүсгэж байна.
3. Тендерийн баримт бичгийг хууль, журамд заасны дагуу боловсруулсан, худалдан авалттай холбоотой зөрчил бага гарсан боловч төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний зураг, төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын боловсруулалтаас шалтгаалан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацааг баримтлаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчигдөх, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч шалгараагүйн улмаас төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэл байсаар байна.
4. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгож ажилласан ч, нийт төсөл, арга хэмжээний 47 хувь нь хэрэгжээгүй, зарим төсөл, арга хэмжээг зураг, төсвийн дагуу гүйцэтгүүлээгүй, хугацаа хоцорсон төсөл, арга хэмжээнүүдийн гэрээний хэрэгжилтийг үнэлж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байгаа нь төсөл, арга хэмжээний гэрээний хариуцлагыг тухай бүр тооцож ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.
5. Тайлант онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлтэй холбоотой зөрчил гараагүй, улсын комисс ажиллан хүлээж авсан байгаа боловч зарим төсөл, арга хэмжээний зохиогч болон захиалагчийн хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, илрүүлсэн зөрчлүүдээ арилгуулж чадаагүй, бетоны бат бэх, заслын ажлын материалын шаардлагад хяналт хэрэгжүүлж дүгнэлт гаргаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулах эрсдэлийг дагуулсаар байна.
6. Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 1,367.8 сая төгрөгийг хөрөнгийг бүртгээгүй, Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Шаардлагатай сумдад/ төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг бүрэн тодорхойлох боломжгүй, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, тайлагнаагүй байгаа нь хөрөнгийн ашиглалт, хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга(Д.Пүрэвдорж)-д

1. Хууль, журамд заасан төсөвлөлтийн шаардлага хангасан зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай хөгжлийн бодлогыг дэмжсэн, төсөл, арга хэмжээнүүдийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх.

Аймгийн Засаг дарга(Л.Төмөрбаатар)-д

1. Хууль, журамд заасан төсөвлөлтийн шаардлага хангасан, зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай, хөгжлийн бодлогыг дэмжсэн, төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга(Э.Аззаяа)-д:

1. Хууль, журамд заасан төсөвлөлтийн шаардлага хангасан, зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай хөгжлийн бодлогыг дэмжсэн, төсөл, арга хэмжээг төлөвлөх,

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засвар, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд авто зам дагуу ойн зурвас байгуулах /Мөрөн сум/ төсөл, арга хэмжээний санхүүжилтээс суутгахаар гэрээнд заасан нормчлолын сангийн шимтгэл 3.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж эрх бүхий байгууллагад шилжүүлэх,

3. Гэрээний хугацаа хэтэрсэн "Ус дулаан дамжуулах төв №12"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох, "Ус дулаан дамжуулах төв №13"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох, Дэвшилтэд технологи бүхий бие даасан эх үүсвэрээр дулааны шугам сүлжээнд холбох ажлын ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчид гэрээний хариуцлага /алданги/ тооцох,

4. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ, хөгжлийн бодлогын уялдааг ханган төлөвлөж, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож тайлагнаж байх.

5. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг хуваарилахдаа тоног, төхөөрөмжийн иж бүрэн байх нөхцөлийг харгалзан хуваарилж ашиглуулах,

Орон нутгийн өмчийн газрын дарга(Ц.Бэхбаяр)-д:

1. Хөвсгөл Ус суваг ХХК-ийн эзэмшлийн төв халуун усны халаалтын зуух, УДДТ-11, УДДТ-12, УДДТ-13 хэрэглэгчдийг нэмж холбох зураг төсөв боловсруулах – 270.0 сая төгрөг, Нэгдсэн эмнэлгийн гадна авто машины зогсоол байгуулах /Мөрөн сум/ - 482.8 сая төгрөг, "Ус дулаан дамжуулах төв №11"-ийн 1-р хэлхээний шугам сүлжээг өргөтгөх ажил /төсвийн зөрүү санхүүжилт/ - 600.0 сая төгрөг нийт 1,352.8 сая төгрөгийн хөрөнгийг өмчид бүртгүүлэх,

2. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Шаардлагатай сумдад/ төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийн ашиглалтын гэрээний төслийг шинэчлэн боловсруулж, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалтын харилцааг тодорхойлж, үр ашгийг тооцож ажиллах,

Худалдан авах ажиллагааны газрын дарга(Б.Базардамбуу)-д:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөн, хэрэгжүүлэх,

2. Хэд, хэдэн төсөл, арга хэмжээнд 1 гүйцэтгэгч шалгарах тохиолдолд санхүү, хүний нөөц, техникийн чадавхыг дахин үнэлж ажиллах

“Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв”ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал(Б.Ганзориг)-д:

1. Барилга байгууламжийн бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандарт, заслын ажлын материалын шаардлагад хяналт хэрэгжүүлж, дүгнэлтдээ тусгаж ажиллах,

2. Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан эсэхэд хяналт хэрэгжүүлж, дүгнэлтдээ тусгаж ажиллах,

Мөрөн сумын засаг дарга(Х.Тайванбаяр)-д:

1. Хууль, журамд заасан төсөвлөлтийн шаардлага хангасан, зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай, хөгжлийн бодлогыг дэмжсэн, төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх,

2. Аюултай хог хаягдал шатаах зуух худалдан авах төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн шатаах зуухны гадна хамгаалалт нь халалтыг тэсвэрлэхгүй салж унасан зөрчлийг арилгуулж чанарын шаардлага хангасан гадна хамгаалалт хийлгэх.

Эрдэнэбулган сумын Засаг дарга(Б.Эрдэнэнаран)-д:

1. Хууль, журамд заасан төсөвлөлтийн шаардлага хангасан, зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай, хөгжлийн бодлогыг дэмжсэн, төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх,

2. Төсвийн хөрөнгө оруулалтын тендер шалгаруулалтын баримт бичгийг баталгаажуулж ажиллах,

3. Худалдан авах ажиллагааны хувийн хэргийн хэргийг цаг хугацаанд бүрдүүлж, архивын нэгж болгож ажиллах

4. Гэрээний хугацаа хэтэрсэн төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчид гэрээнд заасны дагуу алданги тооцож ажиллах,

5. Эрдэнэбулган сумын төсвийн хөрөнгө оруулалтын Зөвлөх үйлчилгээ төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдсэн зураг төсвийг байгууллагын бүртгэлд тусгаж ажиллах,

Зөрчлийн жагсаалт:

/сая төгрөгөөр/

№	Илэрсэн зөрчлийн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 16,251.6 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ Хөвсгөл аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй						5	-
2	Аймгийн Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцээгүй							
3	Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө хөрөнгө оруулалтын саналыг холбогдох байгууллагуудаас аваагүй, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй, эрэмбэлж ажиллаагүй							
4	Төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, заавар журмын дагуу эрэмбэлж төлөвлөөгүй							
5	Зураг, төсөвгүй 19,609.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг төлөвлөн, баталсан							
6	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар техникийн тодорхойлолт, ажлын даалгаваргүй 3,457.0 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээ баталсан							
7	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжих 4 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих онуудад тэнцүү хуваарилаагүй							
8	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлж төлөвлөөгүй							
9	Мөрөн сумын ЗДТГ-ын Брэндбүүк бүтээх(зөвлөх үйлчилгээ) 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ нь Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх жилийн үндсэн чиглэлд нийцээгүй							
10	Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-т автомашин худалдан авах 140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх жилийн үндсэн чиглэлд нийцээгүй							
11	Сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар зураг, төсөвгүй 1,920.0 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээ баталсан							
12	Сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар техникийн тодорхойлолт, ажлын даалгаваргүй 2,471.2 сая төгрөгийн 74 төсөл, арга хэмжээ баталсан							
13	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулаагүй	-					1	-
14	Ус дулаан дамжуулах төв №11-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр ижил төстэй 2 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгчээр шалгарсан, төсөл, арга хэмжээнд ажиллах инженер техникийн ажилчид болон техник тоног, төхөөрөмж нь давхцаж байгаа Бат комплект ХХК/Дулаан хаан констракшн ХХК-тай түншлэлийн гэрээтэй/-ийг шалгаруулсан	-					1	-
15	Эрдэнэбулган сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Бетон зуурагч тоног төхөөрөмж худалдан авах, Цемент худалдан авах, МУЗГ-ын 2024-2027 онд хэрэгжүүлэх эрүүл мэнд шүд хөтөлбөрийн хүрээнд СӨБ, ЕБС-ийн бүх сурагч хүүхдүүдийг сүүгээр хангах 3 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын баримт бичгийг сумын Засаг дарга баталгаажуулж ажиллаагүй	-					1	-

ХӨА-2026/05-21-ШТА-НА

16	Эрдэнэбулган сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим, төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын хувийн хэргийг бүрдүүлж ажиллаагүй	-					1	-	
17	Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засвар, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд авто зам дагуу ойн зурвас байгуулах /Мөрөн сум/ төсөл, арга хэмжээний санхүүжилтээс суутгахаар гэрээнд заасан нормчлолын сангийн шимтгэл 3.0 сая төгрөгийг суутган авч үлдээгүй	3.0					1	3.0	
18	"Ус дулаан дамжуулах төв №11,12,13"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох 3 төсөл, арга хэмжээг зураг төсвийн дагуу гүйцэтгүүлээгүй.	6,872.1				1	6,872.1		
19	Мөрөн сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Аюултай хог хаягдал шатаах зуух худалдан авах төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн шатаах зуухны гадна хамгаалалт нь халалтыг тэсвэрлэхгүй салж унасан	-					1	-	
20	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 4,597.4 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээнүүдийг гэрээнд заасан хугацаа болон 2025 онд багтаан гүйцэтгүүлээгүй	-					1	-	
21	Эрдэнэбулган суманд хэрэгжсэн Цагдаагийн кобанд дулааны дотоод шугам сүлжээ холбох төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа хэтэрсэн 33 хоногт ноогдох 145,200 төгрөгийн алданги, Хил хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа хэтэрсэн 44 хоногт ноогдох 440,000 төгрөгийн алданги нийт 585,200 төгрөгийн алданги суутгаагүй	-					1	-	
22	Барилга байгууламжийн бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандарт, заслын ажлын материалын шаардлагад хяналт хэрэгжүүлээгүй	-					1	-	
23	Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй	-					1	-	
24	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 1,367.8 сая төгрөгийн дараах 4 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	1,367.8					2	1,367.8	
25	Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Шаардлагатай сумдад/ төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 138 нэр төрлийн 1,538.2 сая төгрөгийн үнэ бүхий 739 тоног төхөөрөмжийг сумдын ЗДТГ-т шилжүүлж, иргэдэд гэрээгээр ашиглуулахдаа түрээсэлж байгаа эсэх, худалдаж байгаа эсэх нь тодорхойгүй гэрээний загварыг сумдад хүргүүлж гэрээ хийлгэсэн	-					1	-	
26	Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Шаардлагатай сумдад/ төсөл, арга хэмжээний хүрээнд авсан багц төхөөрөмжүүдийг нэг бүрчлэн тараасан нь төсөл, арга хэмжээний үр ашгийг бууруулсан	-					1	-	
27	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, тайлагнаагүй	-					1	-	
28	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 13 төсөл, арга хэмжээ буюу 46 хувь нь бодлогын зорилтот үр дүнд хүрсэн байна	-							
НИЙТ ДҮН		8,242.9				1	6,872.1	20	1,370.8

Төсөл, арга хэмжээнүүдийн хөгжлийн бодлогын баримт бичгийн нийцэл

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Шинэ, шилжих	Хугацаа		Төсөвт өртөг	Бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх		
				Эхлэх	Дуусах		2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Засаг даргын 2024-2028 оны жилийн үйл ажиллагааны хөтөлбөр	Хөвсгөл аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө
							тусгагдсан эсэх (тийм/үгүй)	тусгагдсан эсэх (тийм/үгүй)	
1	Хөвсгөл аймаг	Аврах анги барих /Галт/	Шилжих	2020	2025	519.4			
2	Хөвсгөл аймаг	Спорт заалны барилга. Шинэ-идэр сум	Шилжих	2020	2025	950.0			
3	Хөвсгөл аймаг	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд төрийн албан хаагчдын орон сууцны засвар, өргөтгөл хийх	Шилжих	2023	2025	50.0			
4	Хөвсгөл аймаг	"Өвсний үндэс - Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрөөс санхүүжүүлсэн Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Нэгдсэн эмнэлгийн засварын ажлын АЗДТГ-аас санхүүжүүлэх санхүүжилт	Шилжих	2024	2025	846.6			
5	Хөвсгөл аймаг	Их засвар ХО - 640 хүүхдийн сургуулийн дээврийн засвар /Сод Эрдэм/	Шилжих	2024	2025	160.0			
6	Хөвсгөл аймаг	Тоног төхөөрөмж худалдан авах /Аймгийн ЗДТГ/	Шинэ	2025	2025	30.0	тийм	тийм	тийм
7	Хөвсгөл аймаг	Аймгийн ЗДТГ-ын дотоод сүлжээ, серверийг шинэчлэх	Шинэ	2025	2025	50.0	тийм	тийм	тийм
8	Хөвсгөл аймаг	Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Шаардлагатай сумдад/	Шинэ	2025	2025	1,600.0	тийм	тийм	тийм
9	Хөвсгөл аймаг	Автомашин худалдан авах /АЗДТГ/	Шинэ	2025	2025	300.0	үгүй	тийм	үгүй
10	Хөвсгөл аймаг	Хүчилтөрөгчийн хоолой худалдан авах /Нэгдсэн эмнэлэг/	Шинэ	2025	2025	42.0	тийм	тийм	үгүй
11	Хөвсгөл аймаг	Шулуун гэдэсний дуран худалдаж авах /Нэгдсэн эмнэлэг/	Шинэ	2025	2025	100.0	тийм	тийм	үгүй

12	Хөвсгөл аймаг	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд авто зам дагуу ойн зурвас байгуулах /Мөрөн сум/	Шинэ	2025	2025	1,500.0	тийм	тийм	үгүй
13	Хөвсгөл аймаг	Дэвшилтэд технологи бүхий бие даасан эх үүсвэрээр дулааны шугам сүлжээнд холбох ажлын ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах	Шинэ	2025	2025	300.0	тийм	тийм	тийм
14	Хөвсгөл аймаг	Сайжруулсан эко түлшний үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах	Шинэ	2025	2025	460.0	тийм	тийм	тийм
15	Хөвсгөл аймаг	Хөвсгөл Ус суваг ХХК-ийн эзэмшлийн төв халуун усны халаалтын зуух, УДДТ-11, УДДТ-12, УДДТ-13 хэрэглэгчдийг нэмж холбох зураг төсөв боловсруулах	Шинэ	2025	2025	300.0	тийм	тийм	тийм
16	Хөвсгөл аймаг	"Ус дулаан дамжуулах төв №11"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажил /Мөрөн сум/	Шинэ	2025	2026	2,372.1	тийм	тийм	тийм
17	Хөвсгөл аймаг	"Ус дулаан дамжуулах төв №12"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажил /Мөрөн сум/	Шинэ	2025	2025	2,500.0	тийм	тийм	тийм
18	Хөвсгөл аймаг	"Ус дулаан дамжуулах төв №13"-д хэрэглэгчийг нэмж төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажил /Мөрөн сум/	Шинэ	2025	2025	2,000.0	тийм	тийм	тийм
19	Хөвсгөл аймаг	Спорт заалны барилга барих /Хөвсгөл, Түнэл сум/	Шинэ	2025	2027	2,156.7	тийм	тийм	үгүй
20	Хөвсгөл аймаг	Иргэдэд үйлчлэх төвийн барилга /Хөвсгөл, Рашаант сум/	Шинэ	2025	2027	2,108.3	тийм	тийм	үгүй
21	Хөвсгөл аймаг	Нэгдсэн эмнэлгийн гадна авто машины зогсоол байгуулах /Мөрөн сум/	Шинэ	2025	2025	492.0	тийм	тийм	үгүй
22	Хөвсгөл аймаг	Аймгийн Цагдаагийн газарт авто машин худалдан авах	Шинэ	2025	2025	25.0	тийм	тийм	тийм
23	Хөвсгөл аймаг	Явуулын тайз, лед дэлгэж худалдан авах /Хөгжимт драмын театр/	Шинэ	2025	2025	120.0	тийм	тийм	үгүй
24	Хөвсгөл аймаг	Хилийн цэргийн 319-р заставд хүүхдийн цэцэрлэгийн анги тохижуулах	Шинэ	2025	2025	40.0	тийм	тийм	тийм
25	Хөвсгөл аймаг	"Ус дулаан дамжуулах төв №11"-ийн 1-р хэлхээний шугам сүлжээг өргөтгөх ажил /төсвийн зөрүү санхүүжилт/	Шинэ	2025	2025	887.2	тийм	тийм	тийм
26	Хөвсгөл аймаг	Хүүхэд залуучуудын соёл, амралтын хүрээлэн, гадна тохижилт, жуулчны гудамж байгуулах /Мөрөн сум/	Шинэ	2025	2027	9,312.5	тийм	тийм	үгүй
27	Хөвсгөл аймаг	Тоног төхөөрөмж худалдан авах /Нэгдсэн эмнэлэг/	Шинэ	2025	2025	120.0	тийм	тийм	үгүй

28	Хөвсгөл аймаг	Их засвар ХО - Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засвар	Шилжих	2022	2025	1,037.4	тийм	тийм	тийм
29	Хөвсгөл аймаг Мөрөн сум	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд Гүний худаг гаргах	шилжих	2024	2025	80.0			
30	Хөвсгөл аймаг Мөрөн сум	2023 онд хэрэгжүүлсэн 3 төсөл, арга хэмжээний чанарын баталгаа, магадалшгүй ажил, хяналтын зардал	шилжих	2023	2025	5.8			
31	Хөвсгөл аймаг Мөрөн сум	Гэрэлтүүлгийн засвар үйлчилгээний сэлбэг худалдан авах	шинэ	2025	2025	50.0	тийм	тийм	
32	Хөвсгөл аймаг Мөрөн сум	9,12 дугаар хорооны босоо тэнхлэгийн авто замын хашлага шинээр тавих	шинэ	2025	2025	196.4	тийм	тийм	
33	Хөвсгөл аймаг Мөрөн сум	Авто замын босоо тэмдэг тэмдэглэгээ	шинэ	2025	2025	85.0	тийм	тийм	
34	Хөвсгөл аймаг Мөрөн сум	Улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг сайжруулахад шаардагдах автомашин худалдан авах (Дотоодын цэргийн 835-р тусгай салбар)	шинэ	2025	2025	50.0	тийм	тийм	
35	Хөвсгөл аймаг Мөрөн сум	Гамшгийн бэлэн байдлыг хангах зорилгоор бараа материал хадгалах контейнер худалдан авах	шинэ	2025	2025	30.0	тийм	тийм	
36	Хөвсгөл аймаг Мөрөн сум	Шаардлагатай багуудад "Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих" тоног төхөөрөмж худалдан авах	шинэ	2025	2025	180.0	тийм	тийм	
37	Хөвсгөл аймаг Мөрөн сум	Цагдаагийн газарт тоног төхөөрөмж худалдан авах (торгуулийн орлогоос)	шинэ	2025	2025	50.0	тийм	тийм	
38	Хөвсгөл аймаг Мөрөн сум	Дулааны станцад Зөөврийн дизель генератор худалдан авах	шинэ	2025	2025	30.0	тийм	тийм	
39	Хөвсгөл аймаг Мөрөн сум	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн дуусгалт (5 дугаар багт)	шинэ	2025	2025	35.0	тийм	тийм	
40	Хөвсгөл аймаг Мөрөн сум	Аюултай хог хаягдал шатаах зуух худалдан авах	шинэ	2025	2025	50.0	тийм	тийм	
41	Хөвсгөл аймаг Мөрөн сум	9 дүгээр цэцэрлэгт агуулах барихад шаардлагатай материалын дэмжлэг үзүүлэх	шинэ	2025	2025	20.0	тийм	тийм	
42	Хөвсгөл аймаг Мөрөн сум	5 дугаар цэцэрлэгийн гадна ханын засвар	шинэ	2025	2025	18.0	тийм	тийм	
43	Хөвсгөл аймаг Мөрөн сум	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах хүрээнд урсгал засварт шаардлагатай материалын дэмжлэг (Хилийн цэргийн 0257 дугаар ангид)	шинэ	2025	2025	15.0	тийм	тийм	

44	Хөвсгөл аймаг Мөрөн сум	2 дугаар багийн 2-35 дугаар гудамжинд гэрэлтүүлэг нэмэгдүүлэх	шинэ	2025	2025	36.5	тийм	тийм	
